



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 01 сарын 06 өдөр

Дугаар A/03

Арвайхээр

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
бусдад шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нэр бүхий газар эзэмшигчдийн гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт байрлах 3 нэгж талбарын газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгжийн эзэмшил газрыг зориулалтын дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг тус тус шилжүүлсүгэй.

2.Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/579 дүгээр захирамжийн хавсралтын Өгөөмөр-Өргөө ХХК-тай холбогдох 4 дэх заалт, 2020 оны А/415 дугаар захирамжийн хавсралтын А.Энхтайвантай холбогдох заалт, 2020 оны А/534 дүгээр захирамжийн хавсралтын Ц.Ганбаттай холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100005

Аймгийн Засаг даргын 2021 оны .....  
 дугаар сарын ..... ны өдрийн ..... дугаар  
 захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД  
 ШИЛЖҮҮЛЭХ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

| Д/д | Газар эзэмшигчийн овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Эзэмшигчийн регистрийн дугаар | Газрын зориулалт                                     | Газрын хэмжээ /м <sup>2</sup> /<br>Газраас | Газар эзэмших эрх шилжүүлэн авагчийн овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/ | Эрх шилжүүлэн эзэмшигчийн регистрийн дугаар | Газрын зориулалт                                     | Газрын хэмжээ /м <sup>2</sup> /<br>Газрыг | Газрын байршлын нэр, хаяг                          | Эзэмших хугацаа |
|-----|---|-------------------------------|--|--|--|---|--|---|--|-----------------|
| 1   | Өгөөмөр-Өргөө ХХК                                   | 2681404                       | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 21811                                      | М.Ганбат   | ЙЮ83050619                                  | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 5168                                      | 5 дугаар баг, Барилгачдын гудамж, барилга-20а тоот | 14 жил          |
|     |   |                               |  |  | Өгөөмөр-Өргөө ХХК  | 2681404                                     | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 16643                                     | 5 дугаар баг, Барилгачдын гудамж, барилга-20 тоот  | 14 жил          |
| 2   | Ц.Ганбат  | ЙЙ73011014                    | Амины орон сууц                                      | 451  | Д.Түвшинжаргал   | ЙП96011410                                  | Амины орон сууц                                      | 451                                       | 13 дугаар баг, Дөл-7 гудамж, 706 тоот              | 29 жил          |
| 3   | А.Энхтайван   | ЙЮ78071426                    | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 500  | С.Дуламсүрэн   | ЙЮ84070602                                  | Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор | 500                                       | 13 дугаар баг, Т.Намнансүрэн-2, 207а тоот          | 14 жил          |